

СОРИЛТЫН УР ЧАДВАРЫГ ҮНЭЛЭХ ХӨТӨЛБӨР

/2019 оны I ээлж/

Хамрах хүрээ: Үндэсний түвшинд итгэмжлэгдсэн төрийн, хувийн өмчит, орон нутгийн хяналтын сүлжээ лабораториудын хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, эмийн нян судлалын шинжилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй лабораториуд хамарна.

Хөтөлбөрийн зорилго: Итгэмжлэгдсэн хүнсний лабораториудын хими, микробиологи болон таримал ургамлын үр, хорио цээр, эмийн хяналтын чиглэлээр шинжилгээний үр дүнгийн үнэн зөвийг хянах, шинжилгээний дүнгийн нэгдмэл байдал, хэмжлийн нарийвчлалыг шалгах, гадаад хяналтыг зохион байгуулснаар оролцогч лабораториудын шинжилгээний ур чадварыг дээшлүүлэхэд оршино.

Хөтөлбөр зохион байгуулах чиглэл: Ур чадварын үнэлгээг:

Хими - Гоймонгийн дээжинд уламжлалт аргаар давс %, чийглэг % тодорхойлох,

Сүү, сүүн бүтээгдэхүүнд меламина, афлатоксин-М1 тодорхойлох,

Нян судлал - Шингэн, хатуу хүнс буюу шингэн тэжээлт орчин халдварлуулсан нян, хөгц мөөгөнцөр, ахуйн хэрэглээний бүтээгдэхүүний, бактери үйлчлэх идэвхи тодорхойлох, усан уусмалд стандарт нянгийн тоог тодорхойлох,

Ургамлын эрүүл ахуй хорио цээр - Хог ургамлын үр тодорхойлох,

Эмийн хяналтын лаборатори - Эмийн үйлчлэх бодисыг таних зэрэг үзүүлэлтүүдээр,

Хөтөлбөр хэрэгжих хугацаа: 2019 оны 04 сарын 10-ны өдрөөс 06 сарын 10-ны өдөр хүртэл

Хөтөлбөрийн чиглэл

№	Хөтөлбөрийн чиглэл		Дээж	Үзүүлэлт	Шинжилгээний аргын стандарт
1	Хүнсний химийн шинжилгээ	Уламжлалт	Гоймон	Давс % чийглэг % тодорхойлох	MNS 2233:75 Гоймонгийн шинжилгээний арга MNS 0457:2018 Талх, гурилан бүтээгдэхүүн. Давсны хэмжээг тодорхойлох арга MNS 0245:2005 Гурил ба хивэг шинжлэх арга
		Багажит шинжилгээ	Сүү	Сүү сүүн бүтээгдэхүүнд меламина, афлатоксин-М1 тодорхойлох	MNS 4477:2005 Сүү сүүн бүтээгдэхүүнд афлатоксин М1 тодорхойлох арга ЭАХХС-5.4.01 /Elisa-ийн арга:Байгууллагын стандарт/

2	Микробиологийн шинжилгээ /чанар болон тооны шинжилгээ/	Шингэн хатуу хүнсэнд буюу шингэн тэжээлт орчин	Бактерийн стандарт өсгөвөр тодорхойлох;	MNS ISO 7218:1996 Микробиологи-Микробиологийн шинжилгээний ерөнхий заавар
		Нунтаг ааруул, печеньд	Хөгц мөөгөнцрийн стандарт өсгөвөр тодорхойлох;	MNS ISO 5132:2002 Хүнсний бүтээгдэхүүн Хөгц мөөгөнцар тодорхойлох шинжилгээний арга
		Усан уусмалд	бактерийн тоог тоолох;	MNS 4833:95 Микробиологи 30 ⁰ C-т ургасан бичил биетний колони тоолох ерөнхий арга
		Ахуйн хэрэглээний бүтээгдэхүүнд	Нянд үйлчлэх идэвхи тодорхойлох;	MNS 6236:2011 Нян судлал. Халдваргүйтгэлийн бодисын нянд үйлчлэх идэвхийг тодорхойлох нян судлалын шинжилгээний арга
3	Ургамлын эрүүл ахуй хорио цээрийн шинжилгээ	Үр	Хог ургамлын үр	MNS 2787:2015 Ургамлын өвчин тодорхойлох арга
4	Эмийн шинжилгээ	Эмийн түүхий эд	Эмийн үйлчлэх бодисыг таних	Монгол улсын үндэсний фармакопей

ХАБҮЛЛ-ийн ЭШСЭҮТөв

